



БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв

Төлөвлөгөөний биелэлт хянасан:

Төсвийн төвлөрүүлэн захирагч

Цаг уур орчны шинжилгээний
газрын дарга

..... / Э. БАТТУЛГА /

(албан тушаал)

(гарын үсэг)

тэмдэг

2025.12.10

Төлөвлөгөөний биелэлт тайлагнасан:

Төсвийн шууд захирагч

Ус цаг уур, орчны шинжилгээний
төвийн дарга

..... / С.ОТГОНБААТАР /

(албан тушаал)

(гарын үсэг)

тэмдэг

2025.12.10

(огноо)

№	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ-лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 1.1: Агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжих Уялдаа: Алсын хараа-2050 6.2.17 Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.4.3.7,3.4.3.3 Орхон аймгийн БОУАӨ-ийн салбарт 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээ 1.9, 2.4 Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А/02 тоот тушаал							
1	Арга хэмжээ 1.1.1: Агаарын чанарын хяналт шинжилгээг тасралтгүй хийх	Улсын төсөв	Хүхэрлэг хий ба азотын давхар ислийн дундаж агууламж Мкг/м³	Хүхрийн давхар ислийн хяналт шинжилгэ э-1140 Азотын давхар ислийн хяналт шинжилгээ-1140	Хүхрийн давхар ислийн хяналт шинжилгээ-1140 Азотын давхар ислийн хяналт шинжилгээ-1140 Агаарын чанарын MNS 4585 : 2016 стандартаас хэтрүүлэхгүй	Орхон аймгийн агаарын чанарыг (жилийн эцсийн байдлаар) хотын төв болон гэр хороолол орчмоос хүхрийн давхар исэл 1218 удаагийн давталттай, азотын давхар исэл 1218 удаагийн давталттайгаар сорьц авч хяналт-шинжилгээ хийлээ. Агаарын чанарын индексээр хүйтний саруудад буюу 1,2,3 сарын байдлаар цэвэр түвшинд 3.4%, хэвийн 55.2%, бага бохирдолтой 41.4%, тус тус хүрсэн байна. 4-р сараас эхлэн агаарын чанар харьцангуй сайжирч цэвэр болон хэвийн түвшинд байлаа. Хяналт шинжилгээний өдөр бүрийн дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн санд, агаарын чанарын хяналт шинжилгээний мэдээг агаарын чанарын индексээр үнэлэн өдөр бүр БОУАӨЯ, ОББҮХ, ЦУОШГ-т газарт, сар бүрийн статистик мэдээ болон тайланг ЦУОШГ-ын Орчны шинжилгээний хэлтэст, Орхон аймгийн Статистикийн газарт, хүйтний улиралд сар бүрийн статистик мэдээг аймгийн ХБТХОХ, БОГ, ЭМГ-т хүргүүлэн ажиллаа. Сар бүрийн агаарын чанарын тайлан мэдээг https://orkhon.weather.gov.mn/ сайтад оруулан ард иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна. 2025 оны байдлаар агаарын чанарын хяналт шинжилгээний давтамж 1218 удаа байсан нь өмнөх оноос 6,8-аар өссөн байна. Монгол Солонгосын засгийн газрын хамтарсан төслийн хүрээнд хэрэгжүүлсэн агаарын чанарын судалгааны автомат харуулыг 5 дугаар сараас шинээр ашиглалтанд оруулж 6 төрлийн үзүүлэлтээр хэмжилт хийж байна. 2026 оны эхнээс дээрх станцын хэмжилтийн үр дүн хэрэглэгчдийн гар утсанд харагддаг цахим систем нэвтрүүлнэ. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 100% Бүрэн хангалттай	100%

№	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ-лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
2	Арга хэмжээ 1.1.2 Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, агаарын чанарын хяналт шинжилгээг хуваарийн дагуу хийнэ	Улсын төсөв	Хяналт шинжилгээ хийсэн аж ахуйн нэгжийн тоо, шинжилгээний тоо	Аж ахуйн нэгж-22 Агаарын чанарын хяналт шинжилгээ-112	Аж ахуйн нэгж-22 Агаарын чанарын Хяналт шинжилгээ-112	Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагуудын MNS 4943:2015 Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлагын дагуу болон MNS 6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны ерөнхий шаардлагын дагуу гэрээт хяналт шинжилгээг, ААНБ байгууллагуудын хяналтын цооногийн усанд хяналт шинжилгээ хийж хүргүүлэн ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар “Ачит-Ихт” ХХК, “Эрдмин” ХХК , “Эрдэнэт хивс” ХХК , “Зэс эрдэнэ” ХХК гэх мэт нийт 10 аж ахуйн нэгж байгууллагад нийт 76 агаарын чанарын хяналт-шинжилгээ хийгдсэн байна. 2024 оноос эхлэн олон улсын хэмжээнд мөнгөн усны оксидыг ашиглахгүй хориглосон ба Монгол улсын хилээр нэвтрүүлэхгүй байгаатай холбоотой аж ахуйн нэгжүүдийн шинжилгээг өөрийн нөөцөд байсан бодисоор хийсэн. Цаашид улсын хэмжээнд мөнгөн усны оксид ашиглаж агаарын шинжилгээ хийх боломжгүй болж байгаа тул гэрээт байгууллагуудын агаарын шинжилгээ 2026 онд хийгдэхгүй. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 100% Бүрэн хангалттай	100%
3	Арга хэмжээ 1.1.3: Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх	Улсын Төсөв ОНТ	Бохирдуулагч эх үүсвэрийн тоо ААН, айл өрхийн тоо	Суурин эх үүсвэрийн тоо Аж ахуйн нэгжийн тоо-11 Айл өрхийн тоо- 13935 хөдөлгөөнт эх үүсвэрийн тоо- 26502	Эх үүсвэрийг бүрэн тоолно	Орхон аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн нэгдсэн тооллогыг аймгийн ЗДТГ, БОГ, УЦУОШТ, Авто тээврийн төв, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-ын нийт 100 гаруй албан хаагчийн оролцоотойгоор 14003 айл өрх, 11 аж ахуйн нэгжийн хүчин чадлаар ялгаатай зуух, 33854 авто тээврийн хэрэгслийг тус тус хамруулан 2025 оны 02 сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж тооллоо. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогын арга зүйн талаар 2 сумдын 20 багийн албан хаагчдад сургалт хийж мэдээллээр хангаж ажилласан. “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын дагуу тайлан мэдээг 2025 оны 03 сарын 01-ны дотор аймгийн засаг даргын тамгын газар, ЦУОШГ-т албан тоотоор, егр-ээр ОШХ-ийн мэргэжилтэнд тус тус хүргүүлсэн байна.Эх үүсвэрийн тооллогод хамрагдсан айл өрхийн тоо 68-аар, хөдөлгөөнт эх үүсвэрийн тоо 7352-оор	100%

№	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ-лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						өмнөх оноос нэмэгдсэн харин аж ахуйн нэгжийн тоо өөрчлөлтгүй үзүүлэлттэй байна. Бүрэн хангалттай	
Зорилт 1.2: Усны нөөцийн бохирдол, хомсдолоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах чиглэлээр хяналт шинжилгээг эрчимжүүлэх, гадаргын болон газрын доорх усны бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, хамгаалах Уялдаа: Алсын хараа-2050 6.2.17 Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.4.3.7,3.4.3.3 Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А/02 тоот тушаал							
4	Арга хэмжээ 1.2.1:Гадаргын усанд химийн аналитик шинжилгээг хийж чанарын хяналт тавьж ажиллах	Улсын төсөв	Дээж авсан цэгийн тоо Хяналт шинжилгээ хийсэн тоо	Хангал гол-47 Орхон гол-24 Уртбулаг гол-4 Чингэл гол-4 Дээж авсан нийт цэгийн тоо-79 Хяналт шинжилгээ-1817	Дээж авсан нийт цэгийн тоо-79 Хяналт шинжилгээ-1817	Орхон аймгийн Байгаль орчны шинжилгээний лаборатори нь гадаргын усны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар Хангал голын 4 цэгийн 48, Уртбулаг-Эрдэнэт гол 4, Чингэл-Эрдэнэт гол 4, Орхон голын 2 цэгийн 24 дээжид 23 үзүүлэлтээр нийт 80 дээжид 1840 удаагийн давталттай орчны чанарын хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр Хангал-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Орхон гол 2-р зэрэг буюу Цэвэр, Уртбулаг-Эрдэнэт гол 6-р зэрэг буюу маш бохир, Чингэл-Эрдэнэт гол 2-р зэрэг буюу цэвэр түвшинд байна. Хяналт шинжилгээний дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн сан болон БОХЗТ лабораторид сар бүрийн 1-ны дотор дамжуулж байна. Мөн Орхон аймгийн УЦУОШТ-ийн https://orkhon.weather.gov.mn/ сайтан дээр сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна. Гадаргын усны хяналт шинжилгээний тоо өмнөх оноос 1-ээр, дээжийн тоо 23-аар өссөн байна. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 100% Бүрэн хангалттай	100%
5	Арга хэмжээ 1.2.2:Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, усны	Улсын төсөв	Хяналт шинжилгээ хийсэн тоо	Усны чанарын хяналт шинжилгээ-295	Усны чанарын хяналт шинжилгээ-295	“Ачит-Ихт” ХХК-ны хяналтын цооногийн ус 94, “Эрдмин” ХХК-ны ус 80, “Эрдэнэт хивс” ХХК-ны бохир ус 20, “Зэс -Эрдэнэ” ХХК-ны хяналтын цооногийн ус 83 гэх мэт нийт 10 аж ахуйн нэгж байгууллагын 304 усанд хяналт-шинжилгээ хийгдсэн байна. Хөтөлбөрт болон гэрээт ажлууд хуваарийн дагуу хийгдсэн. Усны хяналт шинжилгээний тоо өмнөх оноос 9-өөр өссөн. Бүрэн хангалттай	100%

№	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ-лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	чанарын хяналт шинжилгээг хуваарийн дагуу хийнэ						
Зорилт 1.3: Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах чиглэлээр хяналт шинжилгээг эрчимжүүлэх Уялдаа: Орхон аймгийн БОУАӨ-ийн салбарт 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээ 4.1 Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А/02 тоот тушаал							
6	Арга хэмжээ 1.3.1:Хөрсний чанарын хяналт шинжилгээг хуваарийн дагуу хийх, төлөв байдлыг тогтоох	Улсын төсөв	Хяналт шинжилгээ хийсэн цэгийн тоо	Хөрсний чанарын хяналт шинжилгээ-55	Хөрсний чанарын хяналт шинжилгээ-55	2025 оны жилийн эцсийн байдлаар “Ачит-Ихт” ХХК-ны хөрс 10, “Эрдмин” ХХК-ны хөрс 15, “Эрдэнэт хивс” ХХК-ны хөрс 1, “Зэс эрдэнэ” ХХК-ны хөрс 6 гэх мэт нийт 10 аж ахуйн нэгж байгууллагад нийт хөрс 33 тус тус хяналт-шинжилгээ хийгдсэн байна. Хөтөлбөрт бус гэрээт ажлууд хуваарийн дагуу хийгдсэн. Хөтөлбөрт хөрсний шинжилгээ улсын сүлжээний хэмжээнд хийгдээгүй болно. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 98% Бүрэн хангалттай	98%
Зорилт 1.4: Орчны бохирдлын чанарын хяналт шинжилгээний ажлыг сайжруулах Уялдаа: Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А/02 тоот тушаал							
7	Арга хэмжээ 1.4.1: Лаборатори хоорондын харьцуулалт, шинжилгээ хийх	Улсын төсөв	Харьцуулалт хийсэн шинжилгээний тоо	БОХЗТЛ-тай харьцуулалт хийсэн тоо-2	БОХЗТЛ-тай харьцуулалт хийсэн тоо-2	Манай лаборатори нь 2025 онд “Шинжилгээний ур чадварыг үнэлэх бүдүүвчинд хамрагдах тухай гэрээ” байгуулан ХАБҮЛЛ-аас зохион байгуулагддаг ур чадварын сорилд оролцож “Хангалттай” гэж дүгнэгдсэн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ус хангамжийн цехийн лабораторитой сар бүр лаборатори хоорондын харьцуулалт хийж байна. Мөн тус үйлдвэрийн байгаль орчны лабораторитой 6 сард гадаргын усаар, байгаль орчин хэмжил зүйн төв лабораторитой 5 сард лаборатори хоорондын харьцуулалтанд оролцлоо. Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториос зохион байгуулагддаг ур чадварын агаарын чанарын хяналт шалгалтанд 4 сард, ус, хөрсний чанарын хяналт шалгалтад 5 сард оролцсон. Нийт 4 удаа харьцуулсан хяналт шалгалтад хамрагдсан нь өмнөх оноос 2 дахин нэмэгдэж “Хангалттай” гэж дүгнэгдсэн. Усны хяналтын дүн 100 хувь Бүрэн хангалттай	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 2.1: Ус цаг уурын мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, нэгдмэл арга зүйгээр хангах							
Уялдаа: Алсын хараа-2050 6.2.19, 6.4.13							
Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.4.1.5, 3.4.2.6							
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, ЗГ-ын 286-р тогтоол,							
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль							
Ус цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаарурьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам							
8	Арга хэмжээ 2.1.1: Цаг уурын улсын сүлжээний өртөө, харуулуудын тасралтгүй ажиллагааг хангаж горимын ажиглалт шинжилгээний хөтөлбөрт ажлыг хийж гүйцэтгэх	Улсын төсөв	Мэдээний тоо УЦУОСМХ-ийн УАӨНС-ны хэлтсээс үнэлсэн ажлын үзүүлэлт - Хувиар	99,4 хувь	99,5 хувь	Хөтөлбөрт ажлууд бүрэн хийгдэж, мэдээллүүд цаг хугацаандаа дамжсан. Хөтөлбөрийн дагуу “Эрдэнэт-Овоо” өртөөнд цаг уурын ажиглалтын мэдээ-2920, цацрагийн мэдээ-730, сарын климат мэдээ-12 удаа, 10 хоногийн климат мэдээ-36, агро дундаж мэдээ-36, аюул мэдээ-64, агаар мэдээ-29 удаа зохиож мэдээлсэн. Өртөө харуулын сар бүрийн шинжилгээний ажлын тайланд техник болон шүүмж шалгалтыг хийж, 12 удаагийн тайланг төвд хүргүүлсэн. Баян-Өндөр, Жаргалант сумдын сарын уур амьсгалын тойм мэдээг 12 удаа гаргаж байгууллагын сайтад байршуулсан. Улаантолгой ХАА-н цаг уурын харуулд цаг уурын ажиглалтын мэдээ 1095, агро дундаж мэдээ-36, аюул мэдээ-24, агаар мэдээ-20 удаа тус тус гаргаж цаг хугацаанд нь төвд дамжуулсан. Улаантолгой харуулын техникч ээлжийн амралтаа биеэр эдлэх хугацаанд харуулыг хаалгүй тасралтгүй ажиллагааг ханган ажилласан . Жаргалант сумын Улаантолгой харуулд Цаг уурын AWS-310 автомат станц суурьлуулах ажил хийгдлээ. Улаантолгой харуулын ажлын байранд төвийн эрчим хүчний тогтвортой цахилгаан хангамжийг шийдвэрлэж 450м урт цахилгааны шугам татаж цаг уурын автомат станц болон ажлын байран дахь цахим төхөөрөмжийг цахилгаанаар хангав. Шинжилгээний ажлын дүн 99,1% Бүрэн хангалттай	99.1%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
9	Арга хэмжээ 2.1.2: Улсын сүлжээ, мэдээ дамжуулалтын тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах	Улсын төсөв	Сүлжээ ашиглалт, мэдээ дамжуулалт хувиар	100 хувь	100 хувь	Төвийн цахим холбооны сүлжээ ашиглалтад гэмтэл, саатал гараагүй. Жилийн эцсийн байдлаар цаг агаарын бодит мэдээ-4015, цацрагийн мэдээ-730 агро мэдээ-72, климат мэдээ-72, аюул мэдээ-64, агаар мэдээ-49, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээ- 40, сэрэмжлүүлэх мэдээ- 15, урьдчилан сэргийлэх мэдээ-1, цаг уурын тайлан -12, урьдчилсан мэдээний тайлан-12, ХААЦУ-ын тайлан-36, багаж, хэмжил зүйн тайлан-2, архив,мэдээллийн дэд сангийн тайлан-2, мэдээлэл үйлчилгээний тайлан- 12, БОШЛ-ын усны тойм мэдээ-12, агаарын бохирдлын мэдээ-12, агаар тойм мэдээ-12, БОУАӨЯ-ны судалгаа-10, төсвийн гүйцэтгэлийн мэдээ-11, санхүүгийн тайлан-1, төсвийн төсөл-1, аудитын тайлан-1, Төрийн өмчийн тайлан-1, ЦУОШГ-т явуулах судалгаа-18 цахимаар илгээсэн. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 100% Бүрэн хангалттай	100%
10	Арга хэмжээ 2.1.3: Улсын сүлжээний цаг уурын өртөө харуулуудын хөдөө аж ахуйн цаг уурын шинжилгээний хөтөлбөрт ажлыг бүрэн хийж гүйцэтгэх	Улсын төсөв	Хөтөлбөрт ажиглалтын тоо, Дүн- хувиар	Бэлчээрийн талбайн хөрсний чийг-27, бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалт хашаалсан талбайд-105 хашаалаагүй талбайд-21 хөнөөлт шавж, мэрэгчдийн ажиглалт-21, мэрэгчдийн голомт нутгийн байрлал, тархалтын ажиглалт-3, Хөрсний чийгийн	182 удаагийн ажиглалтыг бүрэн гүйцэтгэнэ 100 хувь	ЦУОШГ-ын даргын “ХААЦУ-ын хяналт шинжилгээний ажлын өргөтгөсөн хөтөлбөр”-ийн дагуу ажлууд бүрэн хийгдсэн. Өвлийн бэлчээрийн явуул судалгааны ажиглалтыг нийт 7 зогсоол цэгт судалгааг хийж цасан бүрхүүлийн байдал, өвөлжилт зудын байдал, зудын эрсдэлийн үнэлгээг тооцож тойм мэдээ гаргаж мэдээлсэн. Хөрсний чийгийн ажиглалтыг 3 сарын 1-ээс 11 сарыг дуустал сар бүрийн 10,20,31-ны өдөр мэдээг хураан авч үр дүнг боловсруулан, ашигтай чийгийн нөөцийг гүн тус бүрээр, нийт 27 удаа тодорхойлсон. Бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалтыг хашаалсан талбайд 105 удаа, хашаалаагүй талбайд 21 удаа тодорхойлж үе шатны хатаамал хийсэн. Бэлчээрийн ургамлын хөнөөлт шавьжны ажиглалт 21 удаа, мэрэгчдийн ажиглалтыг 4,6,8 дугаар саруудад ажиглаж тайлан мэдээг хүргүүлсэн. Жаргалант суманд 4,10 дугаар сард хаврын угтвар, намрын нөөц чийгийг уринш, гуурстай талбай, хадлан бэлчээрийн талбайд 0-100 см хүртэл гүнд тодорхойлов. ХААЦУ-ын ажиглалтын мэдээний бүтэц, мэдээ	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
				хавар, намрын аялан судалгаа-2, цасан бүрхүүлийн судалгаа-1, төлөв байдлын аялан судалгаа-1, таримал ургамлын явуул судалгаа-1 100 хувь		дамжуулалтанд хяналт тавин, техник, шүүмж шалгалтыг 10 хоног тутамд хийсэн. ХАА-н үйлдвэрлэлд цаг агаар хэрхэн нөлөөлсөн талаар арав хоногийн тойм мэдээг 36, улирлын тойм 4 гаргаж иргэн, ААН, төрийн байгууллагуудад хүргэсэн. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 99.99% Бүрэн хангалттай	
11	Арга хэмжээ 2.1.4: Шаардлагатай тохиолдолд цаг агаарын үзэгдэлд зориудаар нөлөөлөх ажиллагаа явуулах	Орон нутгийн төсөв	Дүн-хувиар	99.3 хувь	99.4 хувь	ЦУОШГ-ын даргын 2025 оны А/26 тоот тушаалаар Орхон бороо-1 экспедицийн үйл ажиллагааг эхлүүлж бэлэн байдлыг ханган ажилласан. 1. 2025 оны үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд зориулан орон нутгийн төсвөөс олгохоор 10,0 сая төгрөгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж аймгийн Засаг даргын 2025 оны А/279 тоот захирамжаар 5,0сая төгрөгийн санхүүжилтийг авсан. 2. Экспедицийн бэлэн байдлыг хангах эрх зүйн хүрээнд экспедицид ажиллах инженер, жолооч нар цаг агаарт зориудаар үйлчлэх эрхийн сургалтад хамрагдаж үнэмлэх авсан. 3. JFJ-3 борооны пуужин 5 удаагийн гаралтаар 12ш пуужин харваж 9ш пуужингийн нөөц үлдэгдэл дээр ЦУОШГ-аас 07 сарын 05-нд 20ш пуужин, удирдлага пультын хамтаар татан авч нийт 29ш пуужингийн нөөц үлдэгдэлтэй байна. Эдгээрийг тэсрэх материалын агуулахын орлого, зарлагын бүртгэл хөтлөн агуулахад хадгалж байна. 4. Үүлэнд зориудаар нөлөөлөх 4-р сарын 25-ний өдөр Булган аймгийн Бугат сумын 1-р баг Гүенгийн булаг гэдэг газарт нөлөөлөхөөр очсон боловч тухайн өдрийн процесс сарнисан болно. 05 сарын 12-нд Булган аймгийн Бугат сумын 1-р баг Бичигт хад гэдэг газарт байрлан явууллаа. Үйл ажиллагааны үр дүнд Баян-Өндөр суманд 12,0мм, Жаргалант суманд 6,0мм хур тунадас оров. 05-р сарын 19-нд Булган аймгийн Бугат сумын нутаг Зосийн даваанд байрлан явуулсан. Баян-Өндөр суманд 4,0мм, Жаргалант суманд 3,0 мм хур тунадас	73,8%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						оров. 06 сарын 10-нд Булган аймгийн Сэлэнгэ сумын Ингэтийн даваанд байрлан явуулсан. Үйл ажиллагааны үр дүнд Баян-Өндөр суманд 6,4мм, Жаргалант суманд 4,2мм хур тундас оров. 06 сарын 28-нд Булган аймгийн Хангал сумын Майхант гэдэг газарт байрлан явууллаа. Үйл ажиллагааны үр дүнд Баян-Өндөр суманд 19,2мм, Жаргалант суманд 7,0мм хур тундас нэмэгдүүлэн тус тус ажилласан байна. Ажиллагааг Газрын даргын 2023 оны А/100 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зааврыг баримтлан тухайн өдрийн ээлжийн синоптик инженер болон хэлтсийн мэргэжилтэн Г.Амгалан, ИНЕГ-ийн нислэгийг удирдах төвийн диспетчер н.Анхзаяа, н.Энхбаатар, н.Баясгалан, н.Мөнхбаяр нарт мэдэгдэж зөвшилцсөн. 5. ЦАЗН үйл ажиллагааны мэдээг байршуулдаг /http:192.168.110.30/ ws FTP линкид дээрх үйл ажиллагааны кодолсон мэдээг тухай бүрт нь байршуулсан. 6. 2025 оны 05 дугаар сарын 07, 09 дүгээр сарын 24-ны өдрүүдэд Байгаль Орчны салбаруудын байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээ, ЕБС-ийн 4,5,14-р сургууль, Уран эгшиг зэрэг сургуулиудын 5-12 дугаар ангийн 250 орчим сурагчдад ЦАЗН ажиллагааны талаарх ойлголтыг өгч сурталчилсан. 7.Төвийн албан хаагчдад ХАБЭА ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгч бүртгэл хөтөлдөг. 8.ЦАЗН Орхон бороо-1 экспедицийн албан хаагчдыг усны гутал, цув болон бичиг хэрэг зэрэг бусад хөдөлмөр хамгааллын хэрэгслээр ханган ажилласан байна. 9.Ажлын байрны эрсдэлийн үнэлгээний арга, олон улсын туршлага нээлттэй хэлэлцүүлэг 2025.11.25-нд болж төвийн дарга болон ЦАЗН ерөнхий инженер, багаж хэмжилзүй хариуцсан технологич инженер хамрагдлаа. Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 73.8% Хангалттай	

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
12	Арга хэмжээ 2.1.5: Цаг агаарын 12 цаг, 24 цаг, 5 хоногийн урьдчилсан мэдээ, 7 хоног, сар, улирлын урьдчилсан төлөв, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээний таарц чанарыг сайжруулах	Улсын төсөв	Урьдчилсан мэдээний таарц-хувиар	УМ-96,0 хувь ААМО-100 хувь Климат-100 хувь АҮ, ГҮ-91,7 хувь Ерөнхий дүн-96,9 хувь	УМ-96,1 хувь ААМО-100 хувь Климат-100 хувь АҮ, ГҮ-91,7 хувь Ерөнхий дүн-97,0 хувь	10 хоног, сарын климат мэдээг шалгаж, цаг уурын мэдээ дамжуулах системээр алдаагүй мэдээ дамжуулсан.-100% Урьдчилсан мэдээний таарц өмнөх оноос 0.7 хувиар өссөн. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээ-40 удаа, сэрэмжлүүлэх мэдээ-15 удаа, урьдчилсан сэргийлэх мэдээ-1 удаа зохиож таарц-100%. Аюултай үзэгдэл, гамшигт үзэгдэл мэдээлсэн байдал таарц өмнөх оноос 8,3 хувиар өссөн буюу ерөнхий дүнгээр 99,2 хувьтай буюу өмнөх оноос 2,2 хувиар өссөн, сүлжээний хэмжээнд 2 дугаар байранд орсон амжилттай ажилласан байна. УМ-96,7 хувь ААМО-100 хувь Климат-100 хувь АҮ, ГҮ-100 хувь Ерөнхий дүн-99.2% Бүрэн хангалттай	99.2%
Зорилт 2.2:Ус цаг уур, орчны шинжилгээний мэдээ баримтыг архивт шилжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх							
13	Арга хэмжээ 2.2.1: Шинжилгээний архивын үйл ажиллагааг хэвийн явуулах, хяналт тавих	Улсын төсөв	Архивын дүн - хувиар	99,83 хувь	99,84 хувь	2025 онд цаг уурын шинжилгээний нийт 23 хадгаламжийн нэгж, 4880 хуудас цаасан баримт хүлээн авч архивын сан хөмрөгийн өрөөнд байршуулж, хадгаламжийн нэгжийн данс бүртгэлийг хийж баталгаажуулан хүлээж авсан. Мөн цаг уур, ХААЦУ, БОШЛ-ын 1996ш файл, 438.31MB цахим баримт хүлээн авч хадгалж, төрөлжүүлэн мэдээллийн санг он оноор үүсгэн хадгалж байна. БНШК-ын хурлыг 4 удаа хийж тухай бүр асуудлыг шийдвэрлэж хурлын тэмдэглэлийг төвд хүргүүлсэн. Архивын мэдээгээр “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Гал сэнтий” ХХК, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар зэрэг байгууллагад 5 удаа цахим болон цаасаар мэдээ гаргаж үйлчилсэн. Дотоод албан хэрэгцээнд цаасан суурьтай 2 хөмрөгийн 20 хадгаламжийн нэгж баримтаар 7 албан хаагчдад үйлчилсэн. 2023 оны АЕГ-ын даргын А/68 дугаар тушаалын дагуу “Зэс-эрдэнийн хувь” ХХК, “Гал сэнтий” ХХК, ОТК ХХК, “Нарт дизайн” ХХК, “Вотер рековри” ХХК, “Эрдмин”	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						ХХК зэрэг аж ахуй нэгжид 32 хадгаламжийн нэгж баримтаар үйлчилж 967,600 төгрөгийн орлогыг төрийн сангаар дамжуулан байгууллагын дансанд төвлөрүүлэв. Архивын өрөөний чийг, дулааныг 7 хоногт 2 удаа тогтмол хэмжиж, ариутгалыг жилд 2 удаа, цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа нийт ариутгал 2 удаа, цэвэрлэгээ 38 удаа хийж, 76 удаа өрөөний чийг, дулааныг хэмжсэн байна. Баримт шилжүүлгийн данс үйлдэж АМСХ-т хүргүүлж батлуулсан. Архивын баримтын хэсэгчилсэн тооллого хийж нягтлан шалган, нэгдсэн тоо бүртгэл excel файлыг хийж АDRSS программд шивж АМСХ-т хүргүүлсэн. Үүнд: ЦД-1 дэвтэр 19178 хуудас 40 хн, ХД-76 дэвтэр 1144 хуудас 28 хн, термографын лент 14609 хуудас 40 хн, УБХ-1 хүснэгт 3431 хуудас 30 хн, ИХХ-1 хүснэгт 490 хуудас 43 хн нийт 38852 хуудас 181 хн баримт тоолсон. Шинжилгээний архивын үндсэн баримтын мэдээллийг нэгтгэн МАЯГТ-1-ийг боловсруулан хугацаанд нь хүргүүлсэн. АМДС-ын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг бичиж төвийн даргаар хянуулж баталгаажуулан АМСХ-т хүргүүлэв. Өмнөх оноос 0,17 хувиар өссөн дүнтэй байна. Шинжилгээний ажлын нэгдсэн дүнгээр 100% Бүрэн хангалттай	
14	Арга хэмжээ 2.2.2: Мэдээллийн дэд сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах, хяналт тавих	Улсын төсөв	Мэдээллийн дэд сангийн дүн - хувиар	100 хувь	100 хувь	2025 онд цаасан болон цахим баримт бүрдүүлэх төлөвлөгөөний дагуу 23 төрлийн цаасан баримт, 5 төрлийн цахим баримт хүлээн авч архивын сан хөмрөгийн өрөөнд байршуулж, шинжилгээний архивын байнга хадгалах хадгаламжийн нэгжийн данс бүртгэлийг хийж баталгаажуулсан. Үүнд: Цаасан суурьтай баримт -Цаг уур, уур амьсгалын баримтын хөмрөг 1819 хуудас, 9 х.н -БОШЛ-ийн баримтын хөмрөгт 2811 хуудас, 7 х.н -ХААЦУ-ын баримтын хөмрөг 250 хуудас, 7 х.н, нийт цаасан суурьтай 4880 хуудастай 23 х.н-ээр мэдээллийн сангийн баяжилт хийсэн. Цахим баримт -Цаг уурын ажиглалтын автомат станцын 77.47 мв хэмжээтэй 1098 файл -Цаг уурын өртөөний горимын мэдээ 1.98 мв хэмжээтэй 36 файл	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						-Цаг уурын харуулын горимын мэдээ 1.1 мв, 36 файл -2024 оны скайнердсан лентүүд 427,6 мв хэмжээтэй 782 файл -ХААЦУ-ын 0.058 мв хэмжээтэй 41 файл Нийт 438.31 мб (0.43GB) хэмжээтэй 1996 файл мэдээг хүлээн авч хадгалсан. Эрдэнэт-Овоо өртөөний 2024 оны термограф-366ш, гигрограф-366ш, барограф-53ш нийт 785ш лентийг сканердаж бүртгэлийг хугацаанд нь хийж 02-р сарын 28-нд АМСХ-д хүргүүлсэн. 2025 онд: Горимын мэдээллийн санд Эрдэнэт-Овоо өртөөний 1705,9кв, Улаантолгой харуулын 918,9кв нийт 2624,8кв хэмжээтэй файлыг хүлээн авч шалгаж, акт, протоколыг сар бүрийн 10-ны дотор, Эрдэнэт-Овоо өртөөний автомат станцын эх мэдээ Log1, Log2, Log3-нийт 63,16 мв мэдээг цахим актаар хүлээн авч бүртгэл хийж сар бүрийн 5-ны дотор тус тус АМСХ-т хүргүүлсэн. 743 хадгаламжийн нэгжийг АDRSS программд шивж 05 дугаар сарын 14-ны өдөр АМСХ-т ftp сүлжээгээр хүргүүлсэн. 1988-1990 оны ЦД-1 дэвтэр нийт 36ш файл 2143 мв скайнердаж цахим акт, данс, бүртгэлийн хамт 04-р сарын 30-нд цахимаар FTP-д байршуулсан. Баримтыг бүртгэлийн хамт АМСХ-т хүргүүлсэн. Цаасаар 05-р сарын 26-нд АМСХ-д хүргэж өгсөн. Үндсэн үйл ажиллагааны мэдээллийг МАЯГТ-2-ийг боловсруулан хугацаанд нь хүргүүлсэн. АЕГ-ын улсын нэгдсэн тоо бүртгэлд оруулах шинжилгээ судалгааны мэдээ баримтын тоо хэмжээг загвар хүснэгтийн дагуу бэлтгэж 11 дгээр сарын 20-нд хүргүүлсэн. Шинжилгээний ажлын нэгдсэн дүнгээр 100% Бүрэн хангалттай	
Зорилт 2.3: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд стандарт, техникийн шаардлага хангасан хэмжих хэрэгсэл ашиглан нэгдмэл арга зүйгээр хангах, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулгын ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах							
15	Арга хэмжээ 2.3.1: Цаг уурын өртөө, харуулд ашиглагдаж буй хэмжих хэрэгслийн	Улсын төсөв	Баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийн тоо, хувь	Даралтын эталон-1 AWS310 цаг уурын станц-1 100 хувь	Даралтын эталон-1 AWS310 цаг уурын станц-1 100 хувь	Цаг уурын Эрдэнэт-Овоо өртөөний AWS-310 автомат станцын мэдээг БОХЗТЛ-ын улсын шалгагч, инженер Б.Цэрэндорж ирж шалгалтын эталон багажтай харьцуулсан тоололт хийж 05-р сард тоололтыг төвд явуулсан. Агаарын даралтын эталон багажийг БОХЗТЛ-д явуулж 05-р сард шалгалт тохируулгын гэрчилгээ авсан. AWS-310 цаг уурын	99,33%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийх					автомат станцын 1 минут тутамд мэдээ /Төв серверт/ дамжуулах GSM модёмны мэдээ дамжуулалтад өдөр тутам хяналт тавин хэвийн ажиллаж байна. Хэвийн ажиллаж байна. Жаргалант сумын Улаантолгой харуулд Цаг уурын AWS-310 автомат станц суурьлуулах ажил хийгдлээ. Улаантолгой харуулын ажлын байранд төвийн эрчим хүчний тогтвортой цахилгаан хангамжийг шийдвэрлэж 450м урт цахилгааны шугам татаж цаг уурын автомат станц болон ажлын байран дахь цахим төхөөрөмжийг цахилгаанаар хангав. Автомат станц нь тасралтгүй 24 цагаар ажиллаж цаг уурын элементүүдийг минут тутам төвд дамжуулж эхэлсэн. Шинжилгээний ажлын нэгдсэн дүнгээр 99,33% Бүрэн хангалттай	
16	Арга хэмжээ 2.3.2: БОШЛабораторид ашиглагдаж буй хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийх	Улсын төсөв	Шалгалт баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийн тоо хувь	Хэмжих хэрэгсэл-6 Цахилгаан жин-1 Шил сав, хэмжээст хэрэгсэл-16 Туухай-8 Термометр-1 100 хувь	Хэмжих хэрэгсэл-3 Цахилгаан жин-1 100 хувь	Дозиметр RADOS-110 цацрагийн багажийг 2025 оны 4 сарын 2-нд Цөмийн энергийн төвд явуулж баталгаажуулж гэрчилгээ авсан. Өдөр бүр хэмжилт бүрийн өмнө шалгадаг. Агаарын чанарын AL-204 маркын цахилгаан жин, Кондуктометр-BS-820, pH метр-WATERPROOF-PC-8500 багажуудыг тус тус баталгаажуулж гэрчилгээ авсан. Хэвийн ажиллаж байна. Хэмжих хэрэгсэл-3,Цахилгаан жин-1 баталгаажуулалтад хамруулсан. Монгол Солонгосын засгийн газрын хамтарсан төслийн хүрээнд хэрэгжүүлсэн агаарын чанарын судалгааны автомат харуулыг 5 дугаар сараас шинээр ашиглалтанд оруулж 6 төрлийн үзүүлэлтээр хэмжилт хийж байна. Бүрэн хангалттай	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 3.1: Төсвийн шууд захирагч нь цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулах, үйлчлэх, улсын сүлжээний байнгын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, хобогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, байгууллагыг удирдах, тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, бусад төлөвлөгөөг батлах Уялдаа: Алсын хараа-2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам 217 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн 4, 6 дугаар зүйл Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам 206 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар заалт							
17	Арга хэмжээ 3.1.1: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, түүний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих	Үйл ажиллагааны зардлаар	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо	ЦУОШГ-т Гүйцэтгэлийн төлөвлөгөө-1 ЗДТГ ХШҮХ- Гүйцэтгэлийн төлөвлөгөө -1	ЦУОШГ-т Гүйцэтгэлийн төлөвлөгөө-1 ЗДТГ ХШҮХ- Гүйцэтгэлийн төлөвлөгөө -1	ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Орхон аймгийн засаг даргаар баталгаажуулан ЗДТГ-ын ХШҮХ-т, ЦУОШГ-ын даргаар баталгаажуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЦУОШГ-ын ЗАХ-т тус тус хугацаанд нь хүргүүлсэн. Мөн 2 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан төвийн даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө 2 тус тус хугацаанд нь боловсруулж батлуулсан. Хэрэгжилтийг ханган хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд хагас, бүтэн жилийн биелэлтийг хугацаанд нь тайлагнасан. Бүрэн хангалттай	100%
18	Арга хэмжээ 3.1.2: Байгууллагын сургалтын болон нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө, дэд хороо, зөвлөлүүдийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах,	Үйл ажиллагааны зардлаар	Тоо, хувь	Сургалт-1 Нийгмийн баталгааг хангах -1 Дотоод хяналт шалгалт-1 Ёс зүйн дэд хороо-1 Өмч хамгаалах	Дотоод үйл ажиллагааны чиглэлээр батлагдсан төлөвлөгөөнүүдийг бүрэн хэрэгжүүлэх 100 хувь	Төвийн салбар нэгжүүд, дотоод аудит болон бусад зөвлөл, дэд хороо, ажлын хэсгүүд тус тус 2025 онд хийгдэх нийт 12 ажлын төлөвлөгөөг боловсруулж төвийн даргаар баталгаажуулсан. Үүнд: Сургалт-1 Нийгмийн баталгааг хангах -1 Дотоод хяналт шалгалт-1 Ёс зүйн дэд хороо-1 Өмч хамгаалах байнгын зөвлөл-1 Эцэг эхийн зөвлөл-1 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх-1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн-1	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	хэрэгжилтэд хяналт тавих			байнгын зөвлөл-1 Эцэг эхийн зөвлөл-1 Албан хэрэг хос бичгээр хөтлөх-1 Хөгжлийн бэрхшээлтэ й иргэдэд чиглсэн үйл ажиллагаа-1 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх-1		Үндэсний бичиг-1 Авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-1 Архив ба улсын үзлэгт бэлдэх-1 Монгол улсын Ерөнхий сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэх-1 Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад ажлын төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг ханган хяналт тавин ажиллаж байна. Хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайланг ЦУОШГ-ын ЗАХ болон Орхон аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тус тус хугацаанд нь хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар байгууллагын гүйцэтгэлийн тайлан-4 /ЦУОШГ, ЗДТГ-т/, цаг уурын тайлан -12, урьдчилсан мэдээний тайлан-12, ХААЦУ-ын тайлан-12, багаж, хэмжил зүйн тайлан-2, архив,мэдээллийн дэд сангийн тайлан-2, мэдээлэл үйлчилгээний тайлан- 12, БОШЛ-ын усны тойм мэдээ-12, агаарын бохирдлын мэдээ-12, агаар тойм мэдээ-12, БОУАӨЯ-ны судалгаа-10, төсвийн гүйцэтгэлийн мэдээ-11, санхүүгийн тайлан-1, төсвийн төсөл-1, аудитын тайлан-1, Төрийн өмчийн тайлан-1, ЦУОШГ-т явуулах судалгаа-18, байгууллагын ёс зүйн дэд хорооны тайлан-2, эцэг эхийн зөвлөлийн тайлан-2, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх-2, Авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан-2, Монгол улсын Ерөнхий сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэх тайлан-4 удаа тус тус цахим болон цаасан хэлбэрээр хийгдсэн. Тайлан мэдээг холбогдох газар хэлтсийн мэргэжилтэнд хугацаанд нь хүргүүлэхээс гадна и-оффис системд хугацаанд нь оруулж байна. Бүрэн хангалттай	
19	Арга хэмжээ 3.1.3: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн	Улсын төсөв	Бодлогын баримт бигүүдийн тоо	А тушаал-35 Б тушаал-18 Ирсэн бичиг- 192	Баримт бичгийн стандарт MNS 5140:2021-ын хэрэгжилтийг бүрэн хангах	Баримт бичгийн стандарт MNS 5140:2021-ын хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.Төвийн даргын үндсэн үйл ажиллагааны А тушаал 28, боловсон хүчний Б тушаал 19-ыг батлан гаргасан байна. Аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	хэрэгжилтийг хангах, баримт бичгийн стандарт MNS 5140:2021-ын дагуу ажиллах, хяналт тавих			Явуулсан бичиг-197 Өргөдөл-35 Хүсэлт-5		нийт 264 албан бичгийг зохих журмын дагуу бүртгэж, удирдлагад танилцуулан, цохолт хийлгэн и-оффисоор хяналтанд авч холбогдох ажилтанд хүргүүлж цаг тухай бүрт нь хааж буй эсэхэд хяналт тавьж ажиллаж байна. Ирсэн бичиг бүрийг хавсралтын хамт скайнердан цахим хувь үүсгэн хадгалсан. Бүртгэлийн дэвтэрт болон excel файл үүсгэн бичгүүдийг бүртгэж байна. Бүртгэлийн дэвтэр ирсэн бичгийг хэрхэн шийдвэрлэсэн эсэх талаар бүртгэн хааж байна. Аж ахуйн нэгж, байгууллага руу хүргүүлсэн байгууллага хооронд харилцсан нийт 144 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлж, И-Оффис программд шивж, хариутай албан бичигт хяналт тавьж ажиллав. Мөн явуулсан бичиг тус бүрийг хавсралтын хамт скайнердан цахим хувь үүсгэн хадгалсан. Бүртгэлийн дэвтэрт болон excel файл үүсгэн бичгүүдийг бүртгэж байна Төвд албан хаагчдаас хүний нөөц, дотоод асуудлаар өргөдөл-9 , төсөв санхүүгийн асуудлаар хүсэлт-0, үйл ажиллагаатай холбоотой хүсэлт-0 нийт 9 өргөдөл, хүсэлт хүлээн авч хууль тогтоомжид заасан хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгч ажиллалаа. Өргөдөл гомдлын мэдээ тайланг улирал бүрийн дараа сарын 20-ны дотор гаргаж аймгийн ЗДТГ-ын ТЗУХ, ЦУОШГ-ын ЗАХ-т тус тус хүргүүлэн ажиллав.	
	Бүрэн хангалттай						
20	Арга хэмжээ 3.1.4:Монгол улсын ТАЗ-ийн 165 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага, стандарт MNS	Улсын төсөв	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Монгол бичгийн анхан шат-5 Дунд шат-3	Монгол бичгийн анхан шат-15 Дунд шат-6	Тус төв нь албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэглэж байгаа хэвлэмэл хуудаснуудаа Монгол бичиг рүү хөрвүүлж Боловсролын газрын мэргэжилтэнээр хянуулан хэвлэлийн газраар эх бэлдүүлэн Улсын байцаагчаар хянуулж, баталгаажуулсан. Төвийн албан бичгийн А4, А5 хэвлэмэл хуудсыг стандартын дагуу болгож эх бэлдүүлж, тодорхойлолт болон ёс зүйн хорооны тогтоолын хэвлэмэл хуудасны эхийг шинээр бэлдүүлж улсын байцаагчаар хянуулж баталгаажуулсан. Баримт бичгийн стандарт MNS 5140:2021, Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага, стандарт MNS6395:2022 цахим	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	6395:2022 хангуулах хяналт тавих					сургалтад байгууллагын бичиг хэргийн эрхлэгч, аоривч, АМДС-ийн мэргэжилтэн нар хамрагдсан. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP системд УЦУОШТ-ийг бүртгүүлэн админ эрх авч ЦУОШГ-с ирсэн бичиг болон бусад төрийн байгууллагуудаас ирүүлсэн бичгийг цаг алдалгүй хүлээн авч байна. Мөн ERP систем дээр байгууллагын албан бланкыг үүсгэсэн. Төрийн байгууллагын dosx системийг ашиглан мэдээлэл солилцож байна. Албан хаагчдыг шат дараатай монгол бичгийн сургалтад хамруулж байна. Шинээр монгол бичгийн сургалтад анхан шат-15, Дунд шат-6 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. Төвийн нийт 21 албан хаагчид “Үндэсний бичгээр компьютерт бичих” сургалтад хамрагдав. Сургалтыг Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш Б.Баттулга удирдан чиглүүлсэн. Сургалтаар компьютерт Монгол бичгийн фонд суулгах, хуудасны тохиргоо хийх, бичих стандарт, арга зүй, кирилл бичгээс ялгаатай байдал зэргийн талаар ойлголт авч, бичиж сурах дадлага хийв. Түүнчлэн мэргэжлийн багшаас сонирхсон, тулгамдсан асуултдаа хариулт авч, Монгол бичгийн боловсролоо дээшлүүлэн, унших чадвараа ахиулах дадлага ажиллах заавар зөвлөгөө авлаа. Вейб сайт, цахим системд хос бичгийн хэлбэрийг нэвтрүүлэн ажиллаж байна. MNS 6395:2022 Стандартын дагуу хэвлүүлж, харъяа аймгийн архивын мэргэжилтнээр хянуулж, баталгаажуулан албан хэрэг хөтлөлтөд ашиглаж байна. Боловсруулан гаргаж буй баримт бичгээ зөв бичих дүрэм, найруулга зүйн журамласан, хадмал толь ашиглаж, баримтлан ажиллаж байна. Албан хэрэг хөтлөлт болон байгууллагын бүх албан хаагчид баримт бичиг боловсруулахдаа стандарт Mongolian Baiti фондыг ашиглаж тус бүрийн компьютерт суулган ашиглаж байна. Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс гаргасан” Монгол бичгийн алдаа шалгагч, бичиг хөрвүүлэгч программ”-ыг албан хэрэг хөтлөлтөд ашиглаж байна.	

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Бүрэн хангалттай	
21	Арга хэмжээ 3.1.5:Байгууллагын баримтыг архивт шилжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх журмыг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, хяналт тавих	Улсын төсөв	Архивт хүлээн авах цаасан болон цахим баримтын тоо, Хэмжилт, цэвэрлэгээний тоо	Байнга хадгалах баримт-27 ХН Түр хадгалах баримт-13 ХН Цахим баримт-16 МВ баримт хүлээн авсан Чийг, дулаан хэмжилт-88, ариутгал-2, цэвэрлэгээ-44 удаа тус тус хийсэн	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж архивын улсын үзлэгт оролцох	2025 оны байгууллагын архивын ажлын төлөвлөгөө болон архивын улсын үзлэгт бэлдэх төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын байнга хадгалах, түр хадгалах хадгаламжийн нэгжийн Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчилэн БНШК-ийн хурлаар батлуулсан. 2025 онд Түр хадгалах 20 хадгаламжийн нэгж, 3023 хуудас цаасан баримт, Байнга хадгалах 21 хадгаламжийн нэгж, 2188 хуудас цаасан баримт хүлээн авсан. Орхон аймгийн ус цаг уур орчний шинжилгээний төвийн байгууллагын архивд өнөөдрийн байдлаар Байнга хадгалах 147 хадгаламжийн нэгж 14144 хуудас баримт, 70 жил хадгалах 26 хадгаламжийн нэгж 2605 хуудас баримт, Түр хадгалах 87 хадгаламжийн нэгж 16268 хуудас баримт, нийт 260 хадгаламжийн 33017 хуудас баримт хадгалагдаж байна. Мөн бүртгэлийн эмх цэгцгийг ханган, агуулгаар нь ангилсан. Тухайлбал байнга болон 70 жилийн бүртгэл хамт явдаг байсныг салгасан. Бүртгэлийн дагуу шүүгээнд цэгцлэн ойлгомжтой байдлаар ялган байрлуулж, дугаарласан. Төвийн архивт хадгалагдаж буй тус цаасан баримтуудыг цахимжуулах үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар байнга хадгалах 147 хадгаламжийн нэгжийн 14144 хуудас баримт, 70 жил хадгалах 26 хадгаламжийн нэгжийн 2605 хуудас баримт сканердаж цахимжуулжээ. БНШК-ын хурлыг 4 удаа хийж тухай бүр асуудлыг шийдвэрлэсэн. Байгууллагын архиваас 102 хадгаламжийн нэгж баримтаар дотоод ажлын хэрэгцээнд 5 албан хаагчид үйлчилсэн. Архивын өрөөны эмх цэгцтэй байдлыг хангах, цэвэрлэх, чийг дулааны хэмжээг шалгах үйл ажиллагааг тогтмол явуулж байна. Жилийн эцсийн байдлаар нийт ариутгал 2 , цэвэрлэгээ 38 хийж өрөөний чийг, дулааныг 76 удаа хэмжсэн байна. Төвийн архивч, мэдээллийн сангийн мэргэжилтэн нар Орхон аймгийн Нийгмийн даатгалын архивтай танилцаж туршлага судалсан. Архивын ерөнхий	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						газраас зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн 3 хоногийн мэргэшүүлэх болон 1 сарын цахим сургалт, Зангиа академийн цахим сургалтуудад байгууллагын дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн бөгөөд архивч, бичиг хэргийн эрхлэгч, цаг уурын мэдээллийн сангийн ахлах мэргэжилтэн нар хамрагдаж гэрчилгээ авсан байна. -Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан”-ы 1 сарын сургалт -Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Төрийн архивын ажлын зохион байгуулалт” -Зангиа академийн Архивын бүртгэл зохион байгуулалт, Албан хэрэг хөтлөлтийн арга зүй, Үндэсний бичиг, Сэтгэл судлал, Алдаанаасаа суралцах чадамж зэрэг сургалтад хамрагдсан. Монгол улсын Засгийн газрын 2025 оны 07 сарын 09-ны өдрийн Улсын үзлэг зохион байгуулах тухай тогтоол гарсан. Улмаар Орхон аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын урьдчилсан үзлэг зохион байгуулах” А/750 тоот захирамж гарсан. Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд 2025 оны 9 сарын 18-нд Архивын улсын үзлэгийн урьдчилсан үзлэг ирж, шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд архивын үйл ажиллагаа, баримтын хадгалалт хамгаалалт, албан хэрэг хөтлөлтийн стандарт зэргийг шалгав. Тус шалгалтын дүнгээр -Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт 100% -Байгууллагын архивын үйл ажиллагаа 98% -Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа 96.1% -тай дүгнэгдэж, нийлбэр дүнгээр 98% дүгнэгдсэн. Бүрэн хангалттай	
22	Арга хэмжээ 3.1.6: Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг	Үйл ажиллагааны зардлаар	ХАСХОМ мэдүүлсэн	Төвийн дарга-1 ЗТХ-ийн дарга-1	Төвийн дарга-1 ЗТХ-ийн дарга-1 ЦУТМҮХ-ийн дарга-1	Төвийн дарга, хэлтсийн дарга-2, ерөнхий нягтлан бодогч нар ХАСХОМ-аа хуулийн хугацаанд “Авлигатай тэмцэх газар”-ын https://meduuleg.iaac.mn/ сайтад мэдүүлж мэдүүлгийг ЦУОШГ-ын хүний нөөцийн мэргэжилтэнд явуулсан. АТГ-с	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх		албан хаагчдын тоо	ЦУТМҮХ- ийн дарга-1 Ахлах нягтлан бодогч-1	Ахлах нягтлан бодогч-1	зохион байгуулсан авилгаас урьдчилан сэргийлэх нь, анхаарах асуудал сэдэвт цахим сургалтад төвийн удирдлага, 2 хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч бусад албан хаагчид хамрагдсан. 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн ЦУОШГ-ын даргын А/162 дугаар тушаал, төвийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/26 дугаар тушаалуудаар нэгж татан буугдаж 2 хэлтсийн дарга өөр албан тушаалд шилжсэн. ЦУОШГ-ын даргаас ирүүлсэн НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж байгаа тухай тайлан ирүүлэхийг шаардсан 2 албан тоотод хариугаа хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Бүрэн хангалттай	
23	Арга хэмжээ 3.1.7: Нийт албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ТАХ-ийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030 он), “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг зэргийг чанд мөрдөн, ашиг сонирхолын зөрчилгүй ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчийн тоо	Сургалтад хамрагдсан албан хаагч-21 Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч-0	Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төвийн 2025 оны ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган хяналт тавин ажиллаж байна. 2025 оны 04-р сарын 07-нд Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал сэдвээр хойд бүсийн төрийн албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж төвийн ёс зүйн дэд хорооны дарга оролцов. Ёс зүйн дэд хороо нь Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг нийт албан хаагчдад танилцуулан дотоод сүлжээ, веб сайт, ил тод байдлын самбарт байршуулсан. Нийт албан хаагчдад 2025 оны 04 дугаар сарын 16-нд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль /2023.05.04/ түүний хэрэглээ, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм /2019 оны 33 дугаар тогтоолын хавсралт/, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/ зэрэг сэдвээр сургалтыг хийв.Төрийн албаны зөвлөлийн цахим сайтуудын мэдээллүүдийг цаг тухай бүр албан хаагчдад мэдээлж байна. Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга ХНУМТ	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						цахим системд дэд хорооны дарга, гишүүдийн мэдээллийг оруулаад байна.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, төрийн албаны шинэтгэл цахим сургалтад 15 албан хаагч хамрагдав. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос төрийн байгууллагын хүнд суртал, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаар сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж нийт албан хаагчид хамрагдсан. 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”-ийн сургалтад хамрагдлаа. Сургалтыг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын “Хууль эрх зүйн хэлтэс”-ийн Эрх зүйн хөтөч Г.Ганчимэг удирдан чиглүүлж, хуулийг хэрхэн ухаж ойлгох талаар болон онцлох чухал зүйл заалтууд, анхаарвал зохих асуудлын хамт тайлбарлаж өгөв. төв фэйсбүүк пэйж хуудсаар болон https://orkhon.namem.gov.mn/ сайтаар дамжуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн зүйл заалтуудыг олон нийтэд сурталчлах, төвийн албан хаагчдад таниулах ажлыг хийдэг. Мөн байгууллагын зарим байршилд, нүдэнд тусах газар хэвлэн байршуулсан. Жилийн эцсийн байдлаар “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” зөрчсөн албан хаагч 1 байна. Ажлын байранд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн, эсвэл хэрэглэсэн үедээ ажилдаа ирсэн ажилтан байхгүй. Ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, албан хаагчтай холбоотой санал гомдол ирээгүй бүртгэгдээгүй байна. Байгууллагаас төрийн албан хаагчийн ёсзүйн хэм хэмжээг баримтлах, авлига албан тушаал хэрэгт холбогдохгүй байх, дүрэм журмаа мөрдөх, тэгш шударга хүртээмжтэй ажиллах чиглэлээр олон хөтөлбөр, сургалт үйл ажиллагаанд хамрагдсан албан хаагчид байгууллагын бусад ажилтнуудад мэдлэг мэдээлэл түгээн ажиллав. Байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг	

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						баримтлах, тэгш шударга хүртээмжтэй ажиллах, эрсдэлээс сэргийлэх, дутагдлын хажуугаар дүүгай өнгөрөхгүй байх чиглэлээр, хамтарсан сургалт мэдээлэл түгээн ажиллав. Бүрэн хангалттай	
24	Арга хэмжээ 3.1.8: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Дотоод хяналт шалгалт хийсэн тоо	ЗТХ-7 ЦУТМҮХ-8	Дотоод хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар дотоод хяналт шалгалтыг Эрдэнэт-Овоо өртөөнд-3, Улаантолгой харуулын үйл ажиллагаанд-2, урьдчилан мэдээлэхийн технологич инженер-1, уур амьсгалын технологич инженер-1, байгууллагын дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн бөгөөд архивч-1, хүний нөөцийн мэргэжилтэний үйл ажиллагаанд-1, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд-1, ЦАЗН Орхон бороо-1 экспидецийн үйл ажиллагаанд-1, Санхүү-1, бодлогын баримт бичиг-1 зэрэг Захиргаа төлөвлөлтийн хэлтэс-7 удаа, Цаг уурын технологи мэдээлэл үйлчилгээний хэлтэст-9 удаа нийт 16 удаа удирдамж гарган хийж илтгэх хуудас болон ажлын тайлан, акт бичиж дотоод аудит, шалгалтад хамрагдсан албан хаагчдад танилцуулан төвийн даргаар хянуулж заавар, зөвлөгөөг өгч ажилласан. ЦУОШГ-ын Дотоод хяналт шалгалтын баг 2025 оны 07 дугаар сарын 7-9-ны өдрүүдэд ирж ажиллалаа. Ханалт шалгалтын бүрэлдэхүүн төвийн үйл ажиллагаатай танилцаж, тушаал шийдвэр, төсөв, санхүү, нийгмийн баталгаа, архив, мэдээллийн сан, өртөө, харуулын хөтөлбөрт ажил түүний технологи зааврын дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж зөвлөн туслах ажил гүйцэтгэв. Зөвлөн туслах ажлын зөвлөмж хараахан ирээгүй байна. Салбаруудын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн үл тохирлуудыг цаг хугацаанд нь арилгах үүрэг даалгавар өгч, арга хэмжээг авч ажиллалсан. Бүрэн хангалттай	100%
25	Арга хэмжээ 3.1.9: Төвийн хүний нөөцийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний	Үйл ажиллагааны зардлаар	Хувь	100 хувь	100 хувь	Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор ТҮ-ээс "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ыг нэмсэн, Засгийн газрын 238 дугаар тогтоолоор	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	тайлан хөтлөх, ХНУМТ цахим системийн ашиглалтад хяналт тавих, сайжруулах					төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэсэнтэй холбоотой төвийн даргын А/01, А/02 тоот тушаалаар албан хаагчдын зэрэглэл болон үндсэн цалинг шинэчлэн тогтоов. Нийт албан хаагчдад орон нутгийн нэмэгдэлийг 20 хувиар олгож байна. Мөн бусад нэмэгдлүүд болох шөнө цагийн нэмэгдэл, хавсран хослон түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлс, ур чадварын нэмэгдэл, алба хаасан хугацааны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт зэргийг сар бүр зохих журам, тушаал шийдвэрийн дагуу олгож байна. Нэмэгдэл болон цалингийн өөрчлөлтүүдийг тухай бүр ХНУМТ цахим системд оруулан ажиллаж байна. Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль дүрэм, хөдөлмөрийн дотоод журам бусад эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалтын төлөвлөгөөг жил бүр батлуулан ажиллаж байна. Тус төв нь Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” А/162 дугаар тушаал, Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/26 тоот “Нийт ажилтны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэн зохион байгуулалтын нэгжгүй, 19 албан хаагчтай батлагдсан. Энэхүү тушаалууд нь Засгийн газраас “Төрийн албан хаагчдын тоог 9 хувь бууруулахаар шийдвэрлэсэн”-тэй холбогдуулан гарсан. 2025 онд дээрх тушаалуудыг үндэслэн хүний нөөцийн бүрэлдэхүүнд дараах хөдөлгөөнүүд орлоо. Үүнд: 1.Туршилтын хугацаа нь дуусаад үндсэн ажилтан болсон-2, 2.Орон тооны цомхотголд орсон-2,	

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						3.Албан тушаал буурсан -6 Нийт 10 албан хаагчийн хөдөлгөөний мэдээллийг ХНУМТ системд орууллаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар боловсон хүчинтэй холбоотой төвийн даргын Б тушаал 19-ийг төлөвлөж батлууллаа. Төвийн сул ажлын байр /Лабораторийн ус, хөрсний инженер/-ийн зарлалыг Ус цаг уурын салбарын ажилчдад мэдээлэл хүргэх фэйсбүүк хуудас, байгууллагын “Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудас, Орхон аймгийн ХХҮГ-ын нийгмийн сүлжээнд байршуулан нээлттэй зарласан. Тус ажлын байранд 4 иргэний өргөдөл хүлээн авч нөөцөд бүртгэв. Лабораторийн инженерийн ажлын байрны албан хаагчийг дотооддоо шийдвэрлэж, шилжүүлэн ажиллуулав. Албан хаагчдын 84,2 хувь нь магистр, бакалавр зэрэгтэй, тогтвор суурьшилтай олон жил ажилласан мэргэжлийн инженер, техникч нар байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар ТҮМ шатлалаар 18, ТҮ шатлалаар 1 албан хаагч ажиллаж байгаа юм. Хүйсийн байдлаар 16 хувь эрэгтэйчүүд, 84 хувь эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд насны ангилал, төрд ажилласан жилээр авч үзвэл нийт ажиллагсдын 63.2 хувь 20-40 насныхан ба 1-15 жил ажиллаж байгаа залуу боловсон хүчин байна. Төвийн нийт 19 албан хаагчийг хувийн мэдээллийг ТА3-ын холбогдох холбоосоор оруулж ХНУМТ цахим системд баталгаажуулалт хийгдсэн. Бүрэн хангалттай	
26	Арга хэмжээ 3.1.10:Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Улсын төсөв	Төсөв төгрөг	Батлагдсан төсөв 975,420,200 төгрөг	Батлагдсан төсөв 983,242,700 төгрөг	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр, авлага үүсгэхгүй ажиллаж байна. Төсвийн хуваарилалтаас хамаарч зарим нэг зардал хүрэлцэхгүй байх тохиолдолд зардал хооронд хуваарилалт хийлгэх байдлаар зохицуулалт хийж байна. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар Цалин хөдөлмөрийн хөлсний зардалд 642,249.10 мян.төгрөг, ажил олгогчоос төлж байгаа НДШ зардалд 78,862.23 мян.төгрөг, Ашиглалтын зардалд 11,162.79 мян.төгрөг, Хангамж бараа материалын зардалд 6,486.24 мян.төгрөг, Эд хогшил урсгал	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						- Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын журнал - Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн журнал - Бусад холбогдох баримтууд Бүрэн хангалттай	
29	Арга хэмжээ 3.1.13:Шилэн дансны мэдээг үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээллийг байршуулах	Үйл ажиллага аны зардлаар	Мэдээлэл оруулсан тоо	171 мэдээ	171 мэдээ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дагуу мэдээ тайланг жил, хагас жил, сар бүр, 7 хоног бүр, тухай бүрд оруулах мэдээллийг цаг хугацаанд нь оруулсан. 2025 онд Шилэн дансанд 171 мэдээг оруулж ажиллахаас 11 дүгээр сарын байдлаар 148 мэдээлэл цаг хугацаанд нь оруулсан байна. Хугацаа болоогүй 23 мэдээ байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй. Бүрэн хангалттай	100%
30	Арга хэмжээ 3.1.14: Санхүүгийн аудитын хяналт шалгалтад хамрагдаж өр төлбөргүй, зөрчилгүй ажиллах	Улсын төсөв	Зөвлөмж, актын тоо	Зөвлөмж-2 Акт-0	“Өөрчлөлтгүй” дүгнэгдэх	2024 оны санхүүгийн тайланд хийсэн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэгдэж 1 зөвлөмж, 1 албан шаардлага авч ажилласан. Тус Аудитаар илэрсэн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилласан. Бүрэн хангалттай	100%
31	Арга хэмжээ 3.1.15: Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулах, ажлын байрны тав тух, ажиллах	Үйл ажиллага аны орлого	Нийгмийн баталгаа, дэмжлэгт хамрагдсан албан хаагчдын тоо	Албан хаагчид-21 Ахмад ажилчид-20 Албан хаагчдын хүүхэд-36	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төвийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөө 2025 оны 1 дүгээр сарын 10-нд гарган төвийн даргаар батлуулав. Тус төлөвлөгөөний дагуу 2025 оны турш гүйцэтгэл ханган ажиллаж байна. Төвийн албан хаагчдыг ажлын тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгслээр сар бүр хангаж ажил үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлдэг. БОШЛ-ын албан хаагчдад бээлий, маск, халад, ээлжийн ажилтан болон ЦАЗН Орхон бороо-1 экспедицийн албан хаагчдыг усны гутал, цув болон бичиг хэрэг зэрэг бусад хөдөлмөр хамгааллын хэрэгслээр ханган	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	орчин нөхцлийг сайжруулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх					ажилласан байна. Албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө ажил олгогчоос ажилтанд олгох цалин хөлс, орон нутагт ажилласны нэмэгдэл, хоол унааны нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, хортой нөхцлийн нэмэгдэл, мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл зэргийг холбогдох журмын дагуу олгож, шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлдэг. Засгийн газраас баталсан журмын дагуу албан хаагчдад ажлын үйл ажиллагааны үр дүнг дүгнэж хагас, бүтэн жилээр мөнгөн урамшуулал олгодог.Төвийн албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу сар бүр төлөлт, бичилтийг хийж тайланг аймгийн НД-ын хэлтэст өгч НДШ цахим системд оруулж байна. Албан хаагчдын эрүүл мэндийн даатгалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шимтгэлийг төлж байна. Долоо хоног бүрийн 1 дэх өдөр аймгийн захиргааны арын зааланд тогтмол заал авдаг бөгөөд, 10 дугаар сарын 01-ээс 05 дугаар сарын 31-ийг дуусталх хугацаанд тогтмол зааланд сагсан бөмбөг, гар бөмбөг тоглож төвийн албан хаагчдыг хамруулсан болно. Төвийн эцэг эхийн зөвлөл 2025 төлөвлөгөөний дагуу арга хэмжээг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна. Бүрэн хангалттай	
32	Арга хэмжээ 3.1.16: Байгууллагын гадна, дотно орчинг эко байдлаар тохижуулж, албан хаагчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх	Улсын төсөв	Засвар үйлчилгээ хийсэн тоо	Жаргалант сумын Улаантолгой харуулын гадна хамгаалалт ын хашаа-1 Улаантолгой харуулын ажлын байр- 1 Эрдэнэт- Овоо	Байгууллагын гадна, дотно орчны чанараа сайжруулах	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж буй бүх нийтээр мод тарих хаврын өдрүүдэд нэгдлээ. 2025 оны 5 дугаар сарын 8-нд төвийн албан хаагч тус бүр 1.2 метрээс дээш өндөртэй 6 ширхэг шархуйс тарив. Нийт 20 албан хаагч 120 мод тарилаа. Улаантолгойн харуул “2024 оны тэргүүний цаг уурын харуул”-аар шалгарч хошой аварга болсон өндөр амжилт үзүүлсэн юм. Улмаар 200 мод тарих эрхээр шагнуулан Улаан толгойд 120, төвийн хашаанд 80 мод тарив. 10 дугаар сарын 02-ны өдөр “Тарлан толгойн энгэр”-т 60 ширхэг бургас тарилаа. 2025.06.06-ны өдөр байгууллагын гадна орчноо тохижуулж, ногоон байгууламжаа нэмэгдүүлэхээр 80 ширхэг мандлын цэцэг тарилаа.	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
				өртөөний ажлын өрөөний засвар-1 БОШЛ-ын өрөөний засвар-1		Байгууллагын гаднах талбайн ногоон байгууламжийг арчилж, хамгаалах арчилгааны ажлын хүрээнд мод, бут сөөг хэлбэржүүлэх ажлыг 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 1-ний өдрүүдэд хийв. Нийт 88 ширхэг шар хуайсанд тайралт хийсэн юм. Мөн байгууллагын гаднах мод бут, зүлэг, цэцэг ногоог цэвэр, ногоон, эрүүл байлгахын тулд тогтмол усаар хангадаг. 5 дугаар сарын 9-ний өдөр Байгууллагын хашаан доторх болон ойр орчмын талбайн зүлгийг самнаж, өнжмөл өвсөө цэвэрлэх ажил хийлээ. Өнжмөл өвсөө цэвэрлээд нэг газар бөөгнүүлэн хогны машин дуудаж ачуулав. 2025 онд нийт 400 ширхэг мод, 80 ширхэг мандлын цэцэг тарьсан байна. Мөн байгууллагын цонх гадна орчин, сандал, хогийн сав, хайс хашлага, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн шон зэргийг угаах, засварлах ажлыг тогтмол хийдэг. Энэ хавар төвийн гаднах хашааны өнгө үзэмжийг сайжруулах, шавардах, будах, өнгийг сэргээх, нурсан эмтэрсэн хэсгийг засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ. Жаргалант сумын Улаантолгой харуулд Цаг уурын AWS-310 автомат станц суурьлуулах ажил хийгдлээ. Улаантолгой харуулын ажлын байранд төвийн эрчим хүчний тогтвортой цахилгаан хангамжийг шийдвэрлэж 450м урт цахилгааны шугам татаж цаг уурын автомат станц болон ажлын байран дахь цахим төхөөрөмжийг цахилгаанаар хангав. Автомат станц нь тасралтгүй 24 цагаар ажиллаж цаг уурын элементүүдийг минут тутам төвд дамжуулж эхэлсэн. Монгол улсын Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, БНСУ-ын Байгаль орчны яамны хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар 21 аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийг агаарын чанарын автомат станцтай болгох ажил үргэлжилж байна. Уг автомат станц нь Орон нутагт агаарын чанарыг 2-3 үзүүлэлтээр үздэг бол Орхон аймагт анхны 6 үзүүлэлтээр үздэг автомат станцыг суурилуулсан. Тус автомат станц нь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрс төрөгчийн дутуу исэл, PM10 тоосонцор, PM2,5 тоосонцор, Озон гэх мэт байгаль орчны суурь	

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						үзүүлэлтүүдийг 24 цаг, 365 хоног тасралтгүй хэмжих хүчин чадалтай.	
						Бүрэн хангалттай	
33	Арга хэмжээ 3.1.17: Албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлуудыг зохион байгуулах	Үйл ажиллага аны зардлаар	Эрүүл мэндийн үзлэг, сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Эрүүл мэндийн үзлэг-14 Сургалт-21	Эрт илрүүлэг болон Эрүүл мэндийн үзлэг- 21 Сургалт-21	Төвийн албан хаагчид 2025 оны 3 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд “Эрдэнэт медиал” эмнэлэгт “Эрт илрүүлэг 2.0” үзлэг оношилгоонд хамрагдав. Төвийн 21 албан хаагч өөрсдийн насны ангилалд тохирсон багц үзлэг оншилгоонд хамрагдан, дараа дараагийн нарийвчилсан үзлэгт мэргэжлийн эмчийн зөвлөгөөний дагуу үзүүлж, эмчлүүлж байна. Мөн өөрсдийн сонголтоор эрдэс бодисын болон Д амин дэмийн шинжилгээнд хамрагдсан. ӨЭМТ-үүдтэй хамтран эрүүл мэндийн сургалтуудыг зохион байгуулж, албан хаагчдын дунд чихрийн шижин, хеликобактери, сахарын шинжилгээнүүдийг авч, цусны даралт, биеийн ерөнхий үзлэг хийлгэж заавар, зөвлөмжийг авч витаминжуулалтыг хийн ажилласан. “Эрүүл Монгол хүн”, “Машингүй өдөр”, “Гүйж суръя” “Соёлыг түгээе”, “Шүдээ хайрлая” “Хорт хавдраас урьдчилан сэргийлье” аянд оролцов. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг сурталчлах аяны хүрээнд “Гүйж суръя” биеийн тамирын арга хэмжээ 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал спортын “Б” зааланд 7 хоног бүрийн Бямба гарагийн 07:20-08:30 цагуудад 1 сарын хугацаатай зохион байгуулагдав. Тус үйл ажиллагаанд Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн хамт олон хоёр хэсэгт хуваагдан бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдлаа. Монгол улсад орчин цагийн биеийн тамир спортын салбар үүсэж хөгжсөний 101 жилийн ойн хүрээнд “ХИЧЭЭЛЛЭЕ-ӨРНҮҮЛЬЕ-ХЭВШЬЕ” сэдэвт Орхон аймгийн төрийн албан хаагчдын “ЦАСНЫ БАЯР-2025” үйл ажиллагаанд оролцлоо.	100%
34	Арга хэмжээ 3.1.18: Засгийн газраас баталсан журмын дагуу үйл	Улсын төсөв	Үр дүнгийн мөнгөн урамшуулал	Албан хаагчид-20	Ажлын үр дүнг үндэслэн олгох	Албан хаагчдын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулалыг хагас жилээр олгосон байна. Мөн ур чадварын нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, хортой нөхцөлийн	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	ажиллагааны үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох		авсан албан хаагчдын тоо			нэмэгдэл, унаа, хоолны хөнгөлөлтийг сар бүр олгож байна. Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 1 албан хаагчийг ТАСЗ-өөс 6 сарын үндсэн цалинтай тэнцэх дэмжлэгт хамруулсан. Бүрэн хангалттай	
35	Арга хэмжээ 3.1.19:Эрхэлсэн ажилдаа идэвхи зүтгэл гарган амжилттай ажилласан албан хаагч болон ахмад ажилчдыг төрийн одон, медаль, салбарын шагналаар шагнуулахаар тодорхойлох	Үйл ажиллага аны зардлаар	Шагнадсан албан хаагч, ахмад ажилтны тоо	Төрийн дээд одон медаль-8 Салбарын шагнал-3 Орон нутгийн шагнал-2	Болзол хангасан албан хаагч болон ахмад ажилчдыг тодорхойлох	Байгаль орчин, ус цаг уурын салбарт үр бүтээл, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа албан хаагчид, ахмадуудаа шагналаа. Үүнд: Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”- оор ахмад-2, Орхон аймгийн ИТХ-ын “Иргэний төлөө”- медалиар 1, нийт 2 ахмад, 1 албан хаагч шагнал урамшуулалд хамрагдлаа. Бүрэн хангалттай	100%
36	Арга хэмжээ 3.1.20:Байгууллаг ын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв Хувь хүн	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	ЦУОШГ-11 ЗДТГ-21 УЦУОШТ-21 Хувь хүн-13	Сургалтын 2025 оны төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад хамруулах	2025 оны жилийн эцсийн байдлаар сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэшүүлэх болон хувь хүний чадварын сургалтуудад доорх байдлаар төвийн бүх албан хаагчид хамрагдсан байна. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалтад албан хаагчдыг хөгжүүлэх, ажлын байран дахь сургалт-13 мэргэшүүлэх сургалт-19 нийт давхардсан тоогоор 87 албан хаагч хамрагдсан. 2025 онд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэх, суралцангаа хөдөлмөрлөх, хөдөлмөрлөнгөө суралцаж буй 6 албан хаагч байна. Тодруулбал, Дархан-Уул аймгийн ХААИС-д 3 албан хаагч магистрын зэрэг хамгаалж, 3 албан хаагч бакалаврын хөтөлбөрт хамрагдаж байна. Байгаль орчин, уур амьсгалын салбарт жендэрийн мэдрэмжтэй түншлэлийг хөгжүүлэх, жендэрт суурилсан төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилго бүхий	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шал гуур үзүү лэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэ- лийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						зөвлөлдөх уулзалтад төвийн 10 гаруй албан хаагч оролцов. MNS ISO/IEC 17025:2018 стандартын сургалтад 2 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. Орон нутаг, ТАЗ, удирдах байгууллагаас зохион байгуулсан 36 сургалт өдөрлөгт 87 албан хаагч давхардсан тоогоор оролцлоо. албан хаагчдад Монгол бичгийг сэргээх, унших, сайжруулах зорилгоор ажилчдын дунд хаалттай групп нээн хичээл бичвэрүүдийг оруулан ажиллаж байна. zangia academy-тай хамтран албан хаагчдыг цахим сургалтад хамруулан гэрчилгээжүүлж байна. Шинээр монгол бичгийн сургалтад анхан шат-11, Дунд шат-5 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. Төвийн нийт албан хаагчид “Үндэсний бичгээр компьютерт бичих” сургалтад хамрагдав. Төвийн албан хаагчдыг суралцах, хөгжих боломжоор байнга хангадаг. Тухайлбал 2025 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар 70 сургалтад давхардсан тоогоор 356 албан хаагч хамрагдсан байна. Тодруулбал, •Байгууллагаас зохион байгуулсан 14 сургалтад 200 албан хаагч •Аймаг, Орон нутгаас зохион байгуулсан 30 сургалтад 80 албан хаагч •Дээд байгууллага буюу ЦУОШГ-аас зохион байгуулсан 12 сургалтад 30 албан хаагч •Бусад буюу хувь хүнийг хөжүүлэх 14 сургалтад 4 албан хаагч хамрагдсан байна. Бүрэн хангалттай	

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГСАЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 4.1: Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байлгана Уялдаа:Алсын хараа-2050 6.2, 6.4,Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 163 дугаар тогтоол Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 13.1,14.1, 15, 15.1, 15.2 заалт							
37	Арга хэмжээ 4.1.1: Улсын сүлжээний өртөө, харуулын мэдээг хяналтын хугацаанд саадгүй дамжуулах	Улсын төсөв	Дамжуулсан мэдээний тоо	Эрдэнэт-Овоо өртөөний цаг уурын ажиглалтын мэдээ-2928, цацрагийн мэдээ-732, сарын климат мэдээ-12, 10 хоногийн климат мэдээ-36, агро дундаж мэдээ-36, аюул мэдээ-52, агаар мэдээ-37 Улаантолгой ХАА-н цаг уурын харуулын цаг уурын ажиглалтын мэдээ-1098, агро дундаж мэдээ-36, аюул мэдээ-39, агаар мэдээ-31	Цаг агаарын горимын мэдээг цаг хугацаанд нь дамжуулсан байх	Төвийн цахим холбооны сүлжээ ашиглалтад гэмтэл, саатал гараагүй. Жилийн эцсийн байдлаар цаг агаарын бодит мэдээ 4015, цацрагийн мэдээ-730 агро мэдээ-72, климат мэдээ-72, аюул мэдээ-64, агаар мэдээ-49, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээ- 40, сэрэмжлүүлэх мэдээ- 15, урьдчилан сэргийлэх мэдээ-1, цаг уурын тайлан -12, урьдчилсан мэдээний тайлан-12, ХААЦУ-ын тайлан-36, багаж, хэмжил зүйн тайлан-2, архив,мэдээллийн дэд сангийн тайлан-2, мэдээлэл үйлчилгээний тайлан- 12, БОШЛ-ын усны тойм мэдээ-12, агаарын бохирдлын мэдээ-12, агаар тойм мэдээ-12, БОУАӨЯ-ны судалгаа-10, төсвийн гүйцэтгэлийн мэдээ-11, санхүүгийн тайлан-1, төсвийн төсөл-1, аудитын тайлан-1, Төрийн өмчийн тайлан-1, ЦУОШГ-т явуулах судалгаа-18 цахимаар илгээсэн. Бүрэн хангалттай	100%
38	Арга хэмжээ 4.1.2: Цаг агаарын 12 цаг, 24 цаг, 5 хоногийн урьдчилсан мэдээ, 7 хоног, сар, улирлын	Улсын төсөв	Мэдээлж үйлчилсэн мэдээний тоо	12 цаг-366, 24 цаг-366, 5 хоног-365, 7	12 цаг-365, 24 цаг-365, 5 хоног-365, 7 хоног- 52,	Хөтөлбөрийн дагуу жилийн эцсийн байдлаар хагас хоногийн, 1 хоногийн, 5 хоногийн урьдчилсан мэдээнүүд тус бүр- 365 удаа, 7 хоногийн урьдчилсан мэдээ- 52, сарын төлөв 12, улирлын урьдчилсан төлөв 12, цаг агаарын аюултай болон	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	урьдчилсан төлөв, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг нийтэд мэдээлэх			хоног- 53, сарын төлөв-12, улирлын төлөв-8, цаг агаарын анхааруулах мэдээ- 33, сэрэмжлүүлэх мэдээ-10, урьдчилан сэргийлэх мэдээ-1, ой хээрийн түймрээс анхааруулах мэдээ-65, сэрэмжлүүлэх мэдээ-28, урьдчилан сэргийлэх мэдээ-5	сарын төлөв-12, улирлын төлөв-6, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, ой хээрийн түймрээс анхааруулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг нөхцөл бүрдсэн үед зохиож мэдээлсэн байх	гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээ- 40, сэрэмжлүүлэх мэдээ-15 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ-1 удаа тус тус зохиосон. Ой хээрийн түймэр гарах нөхцөлийг агаарын хуурайшлын зэргээр тодорхойлох Нестеровын аргачлалаар хавар 3 сарын 20-оос 6 сарын 15 хүртэл өдөр бүр бодож гаргасан. Ой хээрийн түймрээс анхааруулах мэдээ-107, сэрэмжлүүлэх мэдээ- 80, урьдчилан сэргийлэх мэдээ- 51 удаа тус тус гаргаж мэдээг БОГ, ОБГ, Сум дундын ой ангийн мэргэжилтнүүдэд и-оффисоор хүргүүлж байна. Ой хээрийн түймрийн аюул 4-р зэрэгт хүрмэгц е-оффис, Orkhon.weather.gov.mn-д байршуулж аж ахуйн нэгж иргэдэд мэдээлж байна. Хэрэглэгчдэд мэдээллийг шуурхай хүргэх замаар Orkhon.weather.gov.mn цахим сайт, и-оффис систем, Орхон аймгийн УЦУОШТ фэйсбүүк хаягаар өдөр бүр мэдээллийг байршуулж байна. Мөн Орхон аймгийн ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ-т Е-мэйл хаягаар 57 хүнд, утсаар 365 удаа 7 хоногийн мэдээ, сарын урьдчилсан төлөв, улирлын урьдчилсан төлөвийг тогтмол хүргэдэг бөгөөд аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг гарсан тухай бүрд нь хэрэглэгчдэд хүргэсэн. Масс мессеж үйлчилгээгээр давтагдсан тоогоор 11424 удаа цаг агаарын анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээг хүргэсэн байна. Бүрэн хангалттай	
39	Арга хэмжээ 4.1.3: Нислэгтэй үед шаардлагатай мэдээ, мэдээллээр үйлчлэх	Улсын төсөв	Үйлчилсэн мэдээний тоо	ТАФ мэдээ-13, район-13, Угталтын урьдчилсан мэдээ-4, Чиглэлийн урьдчилсан мэдээ-3	Нислэг гарсан тухай бүрд үйлчилсэн байна.	Жилийн эцсийн байдлаар орон нутагт үндсэн хуваарьт нислэг нийт 24 удаагийн нислэг үйлдэж, тойм ТАФ мэдээ-57, Район-57, Чиглэлийн урьдчилсан мэдээ-24 удаа зохиож нислэгт үйлчилсэн. Саатал гаргаагүй. Бүрэн хангалттай	100%
40	Арга хэмжээ 4.1.4: Иргэд, аж ахуйн нэгжид лабораторийн чанарын хяналт шинжилгээ хийх	Улсын төсөв	Үйлчилсэн ААН тоо	ААН-22	Гэрээт ААН-д үйлчлэх	Жилийн эцсийн байдлаар “Ачит-Ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Эрдэнэт хивс” ХХК, “Зэс эрдэнэ” ХХК гэх мэт нийт 10 аж ахуйн нэгж байгууллагад нийт агаарын чанарын хяналт-шинжилгээ 76, усны хяналт шинжилгээ 304, хөрсний хяналт шинжилгээ 33 удаа тус тус хийгдсэн байна.	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Бүрэн хангалттай	
41	Арга хэмжээ 4.1.5: Иргэн ААН-ын байгууллагад архивын лавлагаа гаргах шуурхай үйлчлэх	Улсын төсөв	Иргэн ААН-д архивын мэдээгээр үйлчилсэн тоо	Дотоод ажлын хэрэгцээнд- 9 албан хаагчид 31 ХН баримт ААН- 7 байгууллагад 25 ХН баримт Иргэн-2 3 ХН баримт	Хүсэлт гаргасан иргэн, ААН-д шуурхай үйлчлэх	“Зэс эрдэнийн хувь” ХХК, “Гал сэнтий” ХХК, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар зэрэг байгууллагад архивын олон жилийн мэдээгээр, ОБАлба, ЭБЦТС ТӨҮГ, Орхон АЗЗА ТӨХК, Дотоодын цэрэг, Эрдэнэт үйлдвэр Ус хангамжийн ЦЕХ, Ингүүмэл зам, Номин Тв, Мэдээллийн бирж Тв, аймгийн хэвлэлийн бага хуралд тус тус захиалсан хүсэлтийн дагуу цаг агаарын урьдчилсан болон өнгөрсөн хугацааны мэдээг гаргаж үйлчилсэн. Байгууллагын архиваас 2025 оны байдлаар дотоод албан хэрэгцээнд даргын А, Б тушаал, хурлын тэмдэглэл, бодлогын баримт бичиг, санхүүгийн тайлан, ирсэн явсан бичиг зэрэг 102 хадгаламжийн нэгж цаасан баримтаар 4 албан хаагчдад үйлчилсэн байна. Цаг агаарын тодорхойлолт мэдээгээр 60 удаа үйлчилсэн байна.	100%
						Бүрэн хангалттай	
42	Арга хэмжээ 4.1.6: Төвийн мэдээ, мэдээллийг цахим сувгаар иргэд, ААН, байгууллагад ил тод нээлттэй мэдээлэх	Улсын төсөв	Ашиглаж байгаа цахим суваг	weather.gov.mn, orkhon.namem.gov.mn, shilen.gov.mn, и-оффис	Цахим сайтын мэдээллийг тогтмол оруулж байх	Orkhon.weather.gov.mn-ээр цаг агаарын урьчилсан мэдээ, цаг уур, ХААЦУ, БОШЛ-ын хоног, сар, улирлын тойм мэдээнүүд, и-оффис системд урьдчилсан мэдээллийг тогтмол оруулж байна. Orkhon.weather.gov.mn, Orkhon.namem.gov.mn, shilen.gov.mn цахим сайтууд, байгууллагын пэйж хуудсуудын хөгжүүлэлтийг хийж цаг үеийн болон бусад үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр оруулж байна. ХНУМТ, шилэн данс, ERP систем, docx, и-оффис систем зэргийг ашиглан үйл ажиллагаа явуулж байна. Удирдлагын систем (https://control.e-mongolia.mn/) нь Монгол Улсын төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас бөгөөд төрийн үйлчилгээ, мэдээлэл болон удирдлагын үйл явцыг цахим хэлбэрээр хялбар, шуурхай байдлаар хүргэх зорилготой систем юм. Энэ платформ нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, иргэдэд хялбар хийх боломжийг бий болгож, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд тусалдаг. Энэхүү систем нь төрийн байгууллагуудын ажлыг илүү хурдан, үр дүнтэй, мөн иргэдийн хэрэгцээнд нийцүүлэх зорилготой бөгөөд 2025 оны 11 дугаар 01-нээс эхлэн	100%

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						-Байгууллагын тухай -Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт -Түүхэн замнал -Мэдээ, мэдээлэл -Хууль, эрх зүй, дүрэм, журам, тогтоол, шийдвэр -Үйлчилгээ -Ил тод байдал -Хүний нөөц-албан хаагчийн мэдээлэл -Тайлан зэргийн мэдээллийг оруулж байна. E-Mongolia цахим үйлчилгээнд цаг агаарын урьдчилсан мэдээг байршуулан оруулж хэвшсэн. https://www.youtube.com/@OrkhonTsaguur youtube хуудсыг 2025 оны 5 дугаар сарын 16-нд нээж хөгжүүлэв. Тус хуудаст олон нийтэд салбарын чиг үүрэг, мэргэжлийн ойлголт өгөх, орон нутаг, улсын хэмжээнд явж буй холбоо, хамаарал бүхий бүхий л мэдээлэл, соён гэгүүрүүлэх контент видеог нийтлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 60 видео мэдээлэл нийтлэгдсэн байна. ERP систем дээр байгууллагын албан бланкыг үүсгэсэн. Erdenet.mn сайтад шинээр цаг агаар цэс нэмж оруулан мэдээллийг тухай бүр шинэчлэж байна. Бүрэн хангалттай	

Тайлбар: Төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 9 зорилт, 42 арга хэмжээний хэрэгжилтийг жилээр тайлагнаснаас нийт 36 арга хэмжээ нь 100 хувийн биелэлттэй, 6 арга хэмжээ 73,8-99,99 хувь дунджаар 99,27 хувь байна.